



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Сант сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: СЭА-2024/10-НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn Сүхбаатар сум 2024 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 7036-3040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 7036-3036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Аудитор: Б.Наранцэцэг Утас: 7036-2442 Цахим хаяг: Narantsetsegba@audit.gov.com
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын дүгнэлт	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5-10
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	11-18
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	13
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	18-19
4. Аудитын тайлан	20-23
4.1 Ерөнхий зүйл	20
4.2 Материаллаг байдал	20
4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	21
4.4 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	22
4.5 Дараагийн аудитаар анхаарах асуудал	23
5. Аудитын илрүүлэлт	23-26
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	27-28

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ААТҮГ	Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
АОУС	Аудитын олон улсын стандарт
ГБХЗХГ	Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ЗДНХ	Засаг Даргын нөөц хөрөнгө
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ОНЕО	Орон нутгийн ерөнхий орлого
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ХХС	Хоршоо хөгжүүлэх сан
ХХОАТ	Хүн амын орлогын албан татвар
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



САНТ СУМЫН ЗАСАГ ДАРГА
С.ШИЖИРБААТАР ТАНАА

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2024.03.25 № ЦА-2024/10-ТА-ТА-ТЗ
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Сант сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сант сумын төсвийн төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Сумын ИТХ-ын 2023 оны 08 дугаар сарын 04-ний өдрийн “Сумын 2023 оны тодотгосон төсөв батлах тухай” 77 дугаар тогтоолоор Сант сум нь 348,644.2 мянган төгрөгийн татварын болон татварын бус орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр баталснаас гүйцэтгэлээр 488,412.7 мянган төгрөгийг төвлөрүүлж, төлөвлөгөөг 145.1 хувиар биелүүлсэн байна

Аудитын гол асуудал

ЗДТГ нь байгууллагын эзэмшилд бүртгэлтэй шугамын усны орлого буюу өөрийн үйл ажиллагааны орлогыг бодит тооцоо судалгаанд үндэслэлгүйгээр хэт

бага буюу 500.0 мянган төгрөгөөр төлөвлөж батлуулсан бөгөөд гүйцэтгэлээр төлөвлөгөөнөөс давсан 2,200.0 мянган төгрөгийн орлогыг нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлж, зарцуулсан байна.

Бусад асуудлын хэсэг

Сумын ИТХ нь Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг “Хангалттай” гэж дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд толилуулж, тодруулснаас бусад аудиторын шийдлээр онцлох асуудал байхгүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	467,393.60	445,500.75
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	375,135.70	209,651.71
33	АВЛАГА	76,223.20	215,473.83
35	БАРАА МАТЕРИАЛ	16,034.70	20,375.21
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,142,548.20	2,403,318.49
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,142,548.20	2,403,318.49
39100	Газар	532,632.80	0.00
39200	Биет хөрөнгө	1,533,406.20	1,813,636.89
39300	Биет бус хөрөнгө	76,509.20	589,681.60
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,609,941.80	2,848,819.24
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	168.00	53.1
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	168.00	53.1
41300	Өглөг	168.00	53.1
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,609,773.80	2,848,766.15
51	Засгийн газрын хувь оролцоо	2,609,773.80	2,848,766.15
51100	Засгийн газрын оруулсан капитал	627,122.10	627,122.07
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	627,122.10	627,122.07
51200	Хуримтлагдсан үр дүн	1,630,084.90	1,869,077.27
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	352,566.80	352,566.80
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,609,941.80	2,848,819.24

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,005,187.10	1,797,723.89
11	ТАТВАРЫН ОРЛОГО	255,259.50	419,043.64
110	Орлогын албан татвар	135,081.10	163,806.61
1100	Хувь хүний орлогын албан татвар	135,081.10	188,957.24
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	0.00	-25,150.63
113	Хөрөнгийн албан татвар	59,619.60	93,462.96
118	Бусад татвар, төлбөр, хураамж	60,558.90	161,774.07
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	843,880.70	517,835.26
120	Нийтлэг татварын бус орлого	843,880.70	517,835.26
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	906,046.90	860,844.99
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	872,504.50	1,228,122.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	862,404.50	1,228,122.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	843,275.60	1,226,057.50
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	312,205.40	473,075.68
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	38,459.80	58,539.94
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	258,801.40	43,997.46
2104	Хангамж, бараа материалын зардал	37,022.40	40,408.31
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,676.10	8,902.60
2107	Томилолт, зочны зардал	4,965.00	6,274.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	14,844.70	349,418.36
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	161,300.90	245,441.14
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	19,128.90	2,065.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	10,100.00	0.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	1,132,682.60	569,601.39
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	4,362,447.00	330,834.80
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-3,229,764.50	238,766.59

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,246,790.70	1,371,941.46
11	ТАТВАРЫН ОРЛОГО	255,259.50	434,845.84
110	Орлогын албан татвар	135,081.10	163,806.61
1100	Хувь хүний орлогын албан татвар	135,081.10	188,957.24
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	0.00	-25,150.63
113	Хөрөнгийн албан татвар	59,619.60	109,265.16
118	Бусад татвар, төлбөр, хураамж	60,558.90	161,774.07
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	3,474.00	5,019.50
1181	Газрын төлбөр	37,141.90	138,176.91
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	19,943.00	18,577.66
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	85,484.30	92,052.83
120	Нийтлэг татварын бус орлого	85,484.30	92,052.83
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	906,046.90	845,042.79
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	816,689.50	1,068,901.02
21	УРСГАЛ ЗАРДАЛ	816,689.50	1,068,901.02
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	797,560.60	1,066,836.02
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	312,205.40	476,671.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	38,459.80	59,052.94
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	258,801.40	43,964.36
2104	Хангамж, бараа материалын зардал	36,392.40	40,291.31
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	29,333.80	22,196.90
2107	Томилолт, зочны зардал	4,965.00	6,274.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	14,844.70	350,738.36
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	102,558.20	67,647.15
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	19,128.90	2,065.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	430,101.20	303,040.44
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	384,359.50	311,864.40
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	384,359.50	311,864.40
2200	Дотоод эх үүсвэрээр	384,359.50	311,864.40
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-384,359.50	-311,864.40
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	0.00	-156,660.00
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	0.00	156,660.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	45,741.70	-165,483.96
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	329,394.00	375,135.68
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	375,135.70	209,651.71

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,841,058.43	5,841,058.43
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-331,489.80	-331,489.80
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,509,568.70	5,509,568.70
4	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00
5	Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00
6	Зарласан ногдол ашиг	0.00	0.00
7	Тайлант үеийн үр дүн	-3,229,764.50	-3,229,764.50
8	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,609,773.76	2,609,773.76
9	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,609,773.76	2,609,773.76
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	225.80	225.80
11	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00
12	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00
13	Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00
14	Зарласан ногдол ашиг	0.00	0.00
15	Тайлант үеийн үр дүн	238,766.59	238,766.59
16	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,848,766.15	2,848,766.15

2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт/ хэмнэлт	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,758,513.90	1,465,337.52	293,176.38	83.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,116,562.90	1,031,695.68	84,867.22	92.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,114,219.60	1,029,630.68	84,588.92	92.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	492,078.60	474,303.67	17,774.93	96.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	61,509.80	58,848.57	2,661.23	95.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	372,071.50	359,785.84	12,285.66	96.7
2104	Хангамж, бараа материалын зардал	48,840.80	39,532.17	9,308.63	80.9
2105	Нормативт зардал	275.60	0.0	275.60	0.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	51,541.70	37,259.50	14,282.20	72.3
2107	Томилолт, зочны зардал	9,863.60	6,274.00	3,589.60	63.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	24,339.60	17,354.28	6,985.32	71.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	53,698.40	36,272.65	17,425.75	67.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,343.30	2,065.00	278.30	88.1
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,343.30	2,065.00	278.30	88.1
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	440,388.20	276,981.84	163,406.36	62.9
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	201,562.80	156,660.00	44,902.80	77.7
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,758,513.90	1,413,714.28	344,799.62	80.4
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,333,589.80	1,375,228.30	-41,638.50	103.1
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	424,924.10	38,485.98	386,438.12	9.1
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	177,371.80	-177,371.80	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	125,748.56	-125,748.56	
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	54	54	54	100
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	2	2	2	100
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	26	26	26	100

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	102,223.33
21	УРСГАЛ ЗАРДАЛ	67,340.77
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	37,205.34
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,367.32
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	204.38
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	759.14
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	31,374.50
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	30,135.42
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	30,135.42
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	34,882.56
2251	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	34,882.56
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	102,223.33
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	102,223.33

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн Сант сумын төсвийн төвлөрүүлэн захирагч /цаашид Сант сумын ТТЗ гэх/-ийн 2023 оны үйл ажиллагааны зорилгыг *“Иргэдийн оролцоотой цахим хөгжлийн жил”* гэж тодорхойлсон байна.

Дээрх дэвшүүлсэн зорилт арга хэмжээний хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны стратегийн зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд:

- ✓ Төрийн ажил үйлчилгээний ил тод нээлттэй байдлыг хангах,
- ✓ Төрийн албан хаагчдын сахилга хариуцлагыг дээшлүүлэх,
- ✓ Төсөвт байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулж, иргэдийн оролцоог хангаж хамтран ажиллах,
- ✓ Төрийн бодлого, хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийг хэрэгжүүлэх, сурталчлах, биелэлтийг нь хангах ажлыг нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд зохион байгуулах үндсэн дээр хүн амын хүнсний аюулгүй байдлыг хангах, мал сүргийг өсгөн үржүүлэх, малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах, мал эмнэлэг, үржлийн ажлыг зохион байгуулах, байгалийн гэнэтийн аюул, мал, амьтан, ургамлын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг бүрэн эрхийнхээ хүрээнд авч хэрэгжүүлэх,
- ✓ Харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратегийн төлөвлөлт, хөтөлбөр, төсөл зохиох, зохицуулах, хяналт шинжилгээ хийх, үнэлж дүгнэх, бодлогын удирдамжаар хангах,
- ✓ Харьяалах нутаг дэвсгэрийнхээ болон засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж хоорондын, түүнчлэн бүс нутгийн чанартай үйлдвэрлэл, үйлчилгээ, нийгэм-соёлын зориулалттай барилга байгууламж барьж байгуулахад орон нутгийн болон хувийн хөрөнгө оруулалт хийх ажлыг дэмжиж, зохион байгуулах,
- ✓ Төрийн ажилтныг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх, тэдний ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах,
- ✓ Нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн хэтийн зорилт болон жилийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөл, гүйцэтгэлийн тайлан, орон нутгийн төсвийн болон түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлуулахаар тухайн ИТХ-д оруулах, батлагдсан хөтөлбөр, төсөв, төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах,
- ✓ Нутаг дэвсгэрийнхээ татварын орлогыг хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийн дагуу төвлөрүүлэх, шилжүүлэх ажлыг зохион байгуулах,
- ✓ Төрийн болон тухайн орон нутгийн өмчийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийн биелэлтийг хангах ажлыг зохион байгуулах гэх мэт.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж, бодлого журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Хөдөлмөрийн тухай хуульд 2023 оны 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2023 оны 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Төрийн албаны тухай хуульд 2023 оны 01 дүгээр сарын 06, 05 дугаар сарын 04, 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07, 11 дугаар сарын 10, 12 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 240 дүгээр тогтоолоор төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн тогтоосон,
- Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн сүлжээ,
- Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлөгдөх, хяналт тавих журамд ХХААХҮ-ийн сайдын 2023 оны 10 дугаар сарын 04-ны А/521 тушаалаар журамд нэмэлт өөрчлөлт орсон,
- Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд 2023 оны 01 дүгээр сарын 06, 12 дугаар сарын 07-ны өдөр тус тус нэмэлт өөрчлөлт орсон,
- Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2023 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн А/450 дугаар тушаалаар “Ойн дагалт баялгийг хамгаалах, зохистой ашиглах журам”-ыг шинэчлэн баталсан гэх мэт.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сант сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2021 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн А/58 дугаар захирамжаар баталсан Сэлэнгэ аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад харьяалагдах төсөвт байгууллагуудын хэмжээнд мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөн ажиллаж байна.

Тус байгууллагын үйл ажиллагаанд мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сант сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 238,877.4 мянган төгрөгөөр буюу 1.1 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	375,135.7	209,651.7	-165,484.0
Авлага	76,223.2	215,473.8	139,250.6
Бараа материал	16,034.8	20,375.2	4,340.4
Үндсэн хөрөнгө	2,142,548.1	2,403,318.5	260,770.4
Нийт хөрөнгө	2,609,941.8	2,848,819.2	238,877.4
Өр төлбөр	168.1	53.1	-115.0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	2,609,773.7	2,848,766.1	238,992.4
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,609,941.8	2,848,819.2	238,877.4

Дээрх хүснэгтээс харахад, нийт хөрөнгийн үлдэгдэл 2,848,819.2 мянган төгрөг болж, өмнөх оноос 238,877.4 мянган төгрөгөөр буурсан байна.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эхний үлдэгдэл 375,135.7 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 209,651.7 мянган төгрөг болж, 165,484.0 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	/мянган төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Касст байгаа бэлэн мөнгө			
Банканд байгаа бэлэн мөнгө	375,135.7	209,651.7	165,484.0
Дүн	375,135.7	209,651.7	165,484.0

Эх сурвалж: Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд тайлагнагдсан ОНЕО-ын дансанд 83,903.2 мянган төгрөг, ОНХС-ийн дансанд 110,391.5 мянган төгрөг, ХХС-ийн дансанд 15,357.1 мянган төгрөг зэрэг нийт 209,651.7 мянган төгрөг төрийн сангийн харилцах дансанд байршиж байна.

3.4.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 76,223.2 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 214,153.8 мянган төгрөг болж, 137,930.6 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/ Өсөлт (+), Бууралт (-)
Байгууллагаас авах авлага	1,270.7	2,590.7	0.0
Ажиллагчидтай холбоотой авлага	0.00	4,166.1	4,166.1
Хувь хүмүүсээс авах авлага	6,085.6	6,085.6	0.0
Хувь хүмүүст олгосон зээл	63,251.2	187,595.5	124,344.3
Зээлийн хүүгийн авлага	5,615.7	15,035.9	9,420.2
Дүн	76,223.2	214,153.8	137,930.6

Эх сурвалж: Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Авлага дансны эцсийн үлдэгдэлд дараах авлагууд тайлагнагдсан байна. Үүнд:

- ЗДТГ-ын ажилчидтай холбоотой авлагад нийгмийн даатгалын байгууллагад илүү шилжүүлэн авлага үүсгэсэн 4,166.1 мянган төгрөгийн,
- ЗДТГ-ын байгууллагаас авах авлагын дансанд “Гавшгай ус” ОНӨААТҮГ-аас авах усны төлбөрийн 1,270.7 мянган төгрөгийн, Софтмайд сольюшн ХХК-аар гүйцэтгүүлж буй Сант сумын вэб сайт хөгжүүлэлтийн урьдчилгааны /11 дүгээр сарын 30-ны дотор хийгдэхээр 2,200.0 мянган төгрөгийн гэрээ байгуулсан боловч дуусаагүй/ 1,320.0 мянган төгрөгийн,
- ОНӨО-ын дансанд бүртгэлтэй 2010-2011 онд 5 иргэнд олгосон итгэлийн зээлийн төлөгдөөгүй үлдэгдэл 6,085.6 мянган төгрөгийн /авлагыг барагдуулахаар шүүхийн шийдвэр гүйцэтгэлд шилжүүлэн эвлэрүүлэн зуучлалын журмаар маргаанаа шийдвэрлэхээр тогтсон байна/,
- Хоршоо хөгжүүлэх сангаас олгосон эргэн төлөгдөх зээлийн 187,595.5 мянган төгрөг, зээлийн хүүгийн 15,035.9 мянган төгрөг зэрэг нийт 202,631.4 мянган төгрөгийн авлагууд тус тус тайлагнагдсан байна.

3.4.3 Бараа материал

Бараа материалын дансны эхний үлдэгдэл 16,034.7 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 20,375.2 мянган төгрөг болж, 4,340.4 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/ Өсөлт (+), Бууралт (-)
Бичиг хэргийн материал	40.0	210.0	170.0
Аж ахуйн материал	13,612.4	17,782.9	4,170.5
Бусад хангамжийн материал	2,382.3	2,382.3	-
Дүн	16,034.7	20,375.2	4,340.5

Эх сурвалж: Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Материалын дансны үлдэгдэл 4,340.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 66,574.4 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 62,233.9 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсантай холбоотой байна.

3.4.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 2,721,323.9 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 3,121,734.6 мянган төгрөг болж, 400,410.7 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 6. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга, байгууламж, орон сууц	457,105.3	690,888.7	233,783.4
Авто-тээврийн хэрэгсэл	223,252.9	223,252.9	0.0
Машин тоног төхөөрөмж(компьютер)	102,173.4	113,507.5	11,334.1
Тавилга, аж ахуйн эд хогшил	28,650.5	17,718.4	-10,932.1
Бусад үндсэн хөрөнгө	1,212,000.5	1,475,305.5	263,305.0
Дуусаагүй барилга байгууламж	86,080.3	8,900.0	-77,180.3
Программ хангамж	5,479.0	4,200.0	-1,279.0
Бусад биет бус хөрөнгө	606,582.0	587,961.6	-18,620.4
Дүн	2,721,323.9	3,121,734.6	400,410.7

Эх сурвалж: Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 400,410.7 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 519.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авсан, 1,437.3 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүйгээр хүлээн авсан, аймаг, сумын ОНХС-ийн болон замын сангийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 543,408.8 мянган төгрөгийн гудамжны гэрэлтүүлэг, зам засвар, тоглоомын талбай зэргийг шилжүүлэн авч, сумын ИТХ-ын 2023 оны 74 дүгээр тогтоолоор 40,253.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хассантай холбоотой байна.

3.4.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны үлдэгдэл 168.0 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 53.1 мянган төгрөг болж 114.9 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 7. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажилчидтай холбогдсон өглөг	168.0	0.0	-168.0
Хувь хүнд төлөх өглөг	0.0	20.0	20.0
Бараа үйлчилгээний зардлын өглөг	0.0	33.1	33.1
Дүн	168.0	53.1	-114.9

Эх сурвалж: Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Өр төлбөрийн дансны үлдэгдэлд ЗДТГ-ын цахилгааны 33.1 мянган төгрөгийн, ХХС-ийн хувь хүнд өгөх өглөгийн 20.0 мянган төгрөгийн өр төлбөр тус тус тайлагнагдсан байна.

3.4.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 2,609,773.8 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 2,848,766.1 мянган төгрөг болж, 238,992.4 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 8. Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	627,122.1	627,122.1	0.0
Хуримтлагдсан үр дүн	1,630,084.9	1,869,077.3	238,992.4
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	352,566.8	352,566.8	0.0
Дүн	2,609,773.8	2,848,766.2	238,992.4

Эх сурвалж: Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл өссөн нь хуримтлагдсан үр дүнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт:

Сумын ИТХ-ын 2023 оны 08 дугаар сарын 04-ний өдрийн “Сумын 2023 оны тодотгосон төсөв батлах тухай” 77 дугаар тогтоолоор Сант сум нь тайлант онд 348,644.2 мянган төгрөгийн татварын болон татварын бус орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр баталснаас гүйцэтгэлээр 488,412.7 мянган төгрөгийг төвлөрүүлж, төлөвлөгөөг 145.1 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 9. Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

д/д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Цалин, хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогын албан татвар	104,023.7	154,027.4	50,003.7	148.1
2	Хувь хүний орлогын албан татвар	10,000.0	19,678.1	9,678.1	196.8
3	Хөрөнгийн татвар	4,000.0	2,885.5	-1,114.5	72.1
4	Хадгаламжийн хүүгийн орлого	8,000.0	12,366.3	4,366.3	154.6
5	Хувь хүний орлогын албан татварын буцаалт	-25,150.6	-25,150.6	0.0	100.0
6	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	2,700.0	694.5	-2,005.5	25.7
7	Бууны албан татвар	1,400.0	1,440.0	40.0	102.9
8	Улсын тэмдэгтийн хураамж	2,000.0	3,891.3	1,891.3	194.6
9	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	297.0	625.2	328.2	2.1
10	Хог хаягдлын хураамжийн орлого	2,000.0	503.0	-1,497.0	25.2
11	Газрын төлбөр	10,911.0	11,365.1	454.1	104.2

12	Дуудлага худалдааны орлого	42,081.4	126,812.0	84,730.6	3.0
13	Ойн нөөц ашигласны төлбөр	14,126.7	14,898.3	771.6	105.5
14	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	1,162.0	1,383.8	221.8	119.1
15	Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	1,750.0	2,295.6	545.6	131.2
16	Малын тоо толгойн албан татвар	144,343.0	107,130.3	-37,212.7	74.2
17	Хүү, торгуулийн орлого	20,000.0	48,845.0	28,845.0	2.4
18	Түрээсийн орлого	2,500.0	2,221.9	-278.1	88.9
19	Бусад орлого	2,500.0	2,500.0	0.0	100.0
	Нийт дүн	348,644.2	488,412.7	139,768.5	

Орлогын төлөвлөгөө 139,768.5 мянган төгрөгөөр давж биелсэн нь хүү, торгуулийн орлого 2.4 дахин, цалин, хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогын албан татвар 1.5 дахин, хувь хүний орлогын албан татвар 1.9 дахин, дуудлага худалдааны орлого 3.0 дахин тус тус давж биелснээс голлон шалтгаалсан байна.

Төсвийн орлогод нөлөөлөхүйц хэмжээний төлөвлөгөөнөөс давсан болон тасарсан орлогуудын шалтгааныг тодруулбал:

Давсан орлого

- Дуудлага худалдааны орлого 84,730.6 мянган төгрөгөөр давж биелсэн нь газрын дуудлага худалдааг тайлант онд 4 удаа зохион байгуулсантай холбоотой,
- Цалин, хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого 50,003.7 мянган төгрөгөөр давж биелсэн нь Засгийн газрын 2023 оны 241 дүгээр тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоож цалин хөлс нэмэгдсэнтэй холбоотой,
- Хүү, торгуулийн орлого 28,845.0 мянган төгрөгөөр давж биелсэн нь төлөвлөгөөг багаар баталсантай холбоотой байна.

Тасарсан орлого:

- Малын тоо толгойн албан татвар 37,212.7 мянган төгрөгөөр,
- Хог хаягдлын хураамжийн орлого 1,497.0 мянган төгрөгөөр тус тус тасарсан нь иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудаас төвлөрүүлэх татварыг дутуу төвлөрүүлснээс шалтгаалсан */хог хаягдлын хураамжийн орлогыг төвлөрүүлэх ажлыг зохион байгуулж, ажиллаагүй/,*
- Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар 2,005.5 мянган төгрөгөөр тасарсан нь орлогыг хэт өндрөөр төлөвлөснөөс шалтгаалсан байна.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон зарлагыг 1,598,657.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөсөн байна.

Сумын ИТХ-ын 2022 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 50 дугаар тогтоолоор:

- Орон нутгийн төсвийн орлогыг 335,689.7 мянган төгрөгөөр,

- Аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 669,461.0 мянган төгрөгөөр,
- Төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогыг 500.0 мянган төгрөгөөр,
- Аймгийн ОНХС-аас олгох шилжүүлгийг 203,704.7 мянган төгрөгөөр,
- Урьд оны үлдэгдлээс 143,977.1 мянган төгрөгийг,
- ОНХС-ийн урьд оны үлдэгдлээс санхүүжих 41,389.5 мянган төгрөг,
- ХХС-ийн 203,935.5 мянган төгрөг зэрэг эх үүсвэр болон зардлыг тус бүр 1,598,657.5 мянган төгрөгөөр баталсан байна.

Аймгийн ИТХ-ын 2023 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн 118 дугаар тогтоолоор суманд аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 61,742.6 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн тодотгосонтой холбоотойгоор сумын ИТХ-ын 2023 оны 08 дугаар сарын 04-ний өдрийн 77 дугаар тогтоолоор:

- ✓ Орон нутгийн төсвийн орлогыг 348,644.2 мянган төгрөгөөр,
- ✓ Аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 731,203.6 мянган төгрөгөөр,
- ✓ Аймгийн ОНХС-аас олгох шилжүүлгийг 253,742.0 мянган төгрөгөөр,
- ✓ Төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогыг 500.0 мянган төгрөгөөр,
- ✓ Урьд оны үлдэгдлээс 178,185.4 мянган төгрөгийг,
- ✓ ОНХС-ийн урьд оны үлдэгдлээс санхүүжих 42,303.2 мянган төгрөг,
- ✓ ХХС-ын 203,935.5 мянган төгрөг зэрэг 1,758,513.9 мянган төгрөгөөр буюу нийт орлого, зарлагыг нэмэгдүүлэн тодотгож баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 20 хөтөлбөрт зориулан 1,758,513.9 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 1,116,562.9 мянган төгрөгийг урсгал зардалд, 440,388.2 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд, 201,562.8 мянган төгрөгийг ХХС-ийн эргэн төлөгдөх зээл, үйл ажиллагааны зардалд зарцуулахаар төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгээс 508,655.9 мянган төгрөг, орон нутгийн төсвийн орлогоос 488,412.7 мянган төгрөг, аймгийн ОНХС-аас 253,742.0 мянган төгрөг, Хоршоо хөгжүүлэх сангаас 38,106.0 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 240.0 мянган төгрөг, дансны эхний үлдэгдлээс 124,557.7 мянган төгрөгийг зэрэг нийт 1,413,714.3 мянган төгрөгийн санхүүжилтийг бүрдүүлсэн байна.

Урсгал зардлын гүйцэтгэлийг төлөвлөгөөтэй харьцуулбал цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал 17,774.9 мянган төгрөгөөр, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардал 2,661.2 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 12,285.7 мянган төгрөгөөр, хангамж бараа материалын зардал 9,308.6 мянган төгрөгөөр, нормативт зардал 275.6 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардал 14,282.2 мянган төгрөгөөр, томилолтын зардал 3,589.6 мянган

төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 6,985.3 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардал 17,425.7 мянган төгрөг, тэтгэмж, урамшуулал 278.3 мянган төгрөгөөр тус тус хэмнэгдсэн байна.

Тайлант онд сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 26 төсөл, арга хэмжээнд 440,388.2 мянган төгрөгийн санхүүжилт олгохоор батлагдсанаас гүйцэтгэлээр 276,981.9 мянган төгрөгийн санхүүжилт олгож, хэрэгжээгүй болон хэмнэлтийн үлдэгдлийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 56,307.2 мянган төгрөг, аймгийн ИТХ-аас 300.0 мянган төгрөг, Статистикийн хэлтсээс хагас жилийн мал тооллогын 588.7 мянган төгрөг, ГБХЗХГ-аас хүүхдийн чуулганы арга хэмжээний 600.0 мянган төгрөг, аймгийн ЗДТГ-аас үзэсгэлэн худалдааны шатахуун болон ахмадын баярын арга хэмжээний 1,427.4 мянган төгрөг, аймгийн ОНХС-аас эрх шилжүүлсэн хогийн цэгийн хашаажуулалтын ажлын 35,000.0 мянган төгрөг зэрэг нийт 37,916.1 мянган төгрөг, аймгийн ЗДНХ-өөс 8,000.0 мянган төгрөг зэрэг нийт 102,223.3 мянган төгрөгийн орлого төвлөрсөн байна.

Үүнээс цалин хөлсөнд 2,367.3 мянган төгрөг, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд 204.4 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 2,500.0 мянган төгрөг, хангамж бараа материалын зардалд 759.1 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 31,374.5 мянган төгрөг, биет ба биет бус хөрөнгө худалдан авахад 34,882.6 мянган төгрөг зэрэг нийт 72,087.9 мянган төгрөгийг зориулалтын дагуу зарцуулж, үлдэгдэл 30,135.4 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт татан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгийн эх үүсвэрээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн харьцуулалтын тендер шалгаруулалтын аргаар гүйцэтгэх 7 төсөл, арга хэмжээний /1 төсөл арга хэмжээ нь малын хөлийн албан татварын орлого төвлөрөөгүйгээс хэрэгжээгүй/ худалдан авах ажиллагааны урилгыг ТБОНӨХБАҮХАТ хуульд заасны дагуу tender.gov.mn цахим сайтад бүрэн байршуулж, зохион байгуулсан байна. Үүнд:

/Мянган төгрөгөөр/

Хөрөнгө оруулалтын ажлын эх үүсвэр	Төлөвлөсөн төсөл, арга хэмжээ		Харьцуулалтын арга	
	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн

Аймгийн ОНХС	4	125,000.0	4	125,000.0
Сумын ОНХС	3	115,000.0	2	90,000.0
Нийт дүн	7	330,000.0	6	215,000.0

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Сант сумын төсвийн төвлөрүүлэн захирагч /цаашид *Сант сумын ТТЗ гэх/-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.*

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд татварын тайлантай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Наранцэцэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сант сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 01/51 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үзлээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 872,504.5 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 8,725.0 мянган төгрөгөөр урьдчилан тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Тайлант онд төсөвт материаллаг хэмжээний өөрчлөлт орсон тул гүйцэтгэлийн үеийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт зардал болох 1,465,337.5 мянган төгрөгөөс 1.0 хувиар тооцон **14,653.4** мянган төгрөгөөр тогтоолоо.

4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.3.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд сумын ТТЗ болон харьяа байгууллагуудын шилэн дансны мэдээлэл байршуулалтыг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт 10. ТТЗ болон харьяа байгууллагуудын шилэн дансны мэдээлэл байршуулалт

Д/д	Байгууллагын нэр	Мэдээлбэл зохих	Мэдээлсэн	Хугацаа хоцроосон	Огт мэдээлээгүй
1	Засаг даргын тамгын газар	171	162	9	
2	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	171	161	10	
3	ТТЗ	145	107	38	
	Нийт дүн	487	430	57	

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудаст мэдээлбэл зохих мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилд өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана.”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн албан шаардлагыг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу Санхүүгийн албаны дарга Г.Ууганцэцэгт хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

4.3.2 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Сант сумын ТТЗ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлж, доорх зардлуудыг хэмнэж ажилласан байна. Үүнд:

- Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 6,685.7 мянган төгрөгөөр,
- Хангамж, бараа материалын зардлыг 9,308.6 мянган төгрөгөөр,
- Эд хогшил, урсгал засварын зардлыг 26,862.2 мянган төгрөгөөр,
- Бараа үйлчилгээний бусад зардлыг 10,445.8 мянган төгрөгөөр,
- Албан томилолтын зардлыг 3,589.6 мянган төгрөгийн,

- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийг 6,985.3 мянган төгрөгийг тус тус хэмнэсэн болон
- Харьяа төсөвт байгууллаудын автомашины улсын дугаарыг цэнхэр дэвсгэрээр солих зэрэг ажлыг хийж хэрэгжүүлсэн байна.

4 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.4.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2023 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 122 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар 3 дугаар улирлын санхүүгийн тайланд аудит хийж, байгууллага, түүний орчин, дотоод хяналт, дотоод аудитын талаар ойлголт олж аван эрсдэл тодорхойлж, аудитын ерөнхий стратеги боловсруулсан.

4.4.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 734.2 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 25,627.7 мянган төгрөгийн 5 албан шаардлага хүргүүлэн, 137,086.8 мянган төгрөгийн зөрчилд 4 зөвлөмж өгөгдсөнөөс биелэлтийг аудитаар дахин хянахад 66.7 хувийн хэрэгжилттэй байна.

Хүснэгт 11. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	2	734.2	2	734.2	100.0
Албан шаардлага	6	25,627.7	3	17,931.3	33.3
Зөвлөмж	4	137,086.8	3	137,086.8	75.0
Нийт дүн	12	163,448.7	8	155,752.3	66.7

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмж болон албан шаардлагыг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд зөрчлүүдийг давтан гаргасан байна. Үүнд:

1. ОНЕО-ын дансанд бүртгэлтэй 2010-2011 онд 5 иргэнд олгосон итгэлийн зээлийн төлөгдөөгүй 6,085.6 мянган төгрөгийн үлдэгдэл, ЗДТГ-ын дансанд бүртгэлтэй “Гавшгай ус” ААТҮГ-аас авах 1,270.7 мянган төгрөгийн усны авлагыг барагдуулах арга хэмжээг авч ажиллах зөвлөмжийг хэрэгжүүлээгүйгээс тайлант оны эцэст үлдэгдлээр тайлагнагдаж, зөрчлийг давтан гаргасан тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

2. ЗДТГ нь авлага, өр төлбөр үүсгэсэн, төсвийг зориулалт бусаар зарцуулсан, анхан шатны баримтын бүрдэлгүйгээр ажил гүйлгээг гүйцэтгэсэн зэрэг зөрчилд өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан тул Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх “...хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно” гэсэн заалтын дагуу сумын ЗДТГ-ын дарга А.Одхүү, нягтлан бодогч Ч.Мөнхзаяа нарт сахилгын шийтгэл ногдуулах, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

4.5 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Цаг хугацаа, хүн хүчний хязгаарлагдмал байдлын улмаас ОНХО, ОНХС-ийн эх үүсвэрээр гүйцэтгэгдэж буй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилт, бүртгэл тайлагналтай холбоотой асуудлуудыг тулган баталгаажуулсан боловч төлөвлөлт, гүйцэтгэл, худалдан авах ажиллагаатай холбоотой асуудлуудыг санхүүгийн тайлангийн аудитад бүрэн хамруулах боломжгүй байлаа.

Иймээс “Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын үр дүн”, “ОНХС-ийн 2023 оны хэрэгжилт, үр дүн” сэдэвт гүйцэтгэлийн аудитаар гүнзгийрүүлэн шалгах шаардлагатай юм.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлтэй холбоотой нийт **18,241.7** мянган төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулж, **3,248.9** мянган төгрөгийн залруулагдаагүй алдаанд зөвлөмж өглөө. Үүнд:

Залруулсан алдаа: /18,241.7 мянган төгрөг/

- ИТХ нь санхүүгийн тайлангийн тодруулгад 40.0 мянган төгрөгийн бараа материалын эхний үлдэгдлийг тайлагнаагүй орхигдуулсан,
- ЗДТГ нь санхүүгийн тайлангийн тодруулгад 15,994.7 мянган төгрөгийн бараа материалын эхний үлдэгдлийг тайлагнаагүй орхигдуулсан,
- ЗДТГ нь санхүүгийн тайлангийн тодруулгад үнэ төлбөргүй хүлээн авсан 2,207.0 мянган төгрөгийн бараа материалыг дутуу илэрхийлсэн гэх мэт.

Залруулаагүй алдаа: /3,248.9 мянган төгрөг/

- ЗДТГ нь шинээр орлогод авсан 6 нэр төрлийн үндсэн хөрөнгийн элэгдлийг тооцож, бодуулаагүйгээс санхүүгийн үр дүнг 1,046.1 мянган төгрөгөөр дутуу илэрхийлсэн байна.
- ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлж буй айл өрхөөс авах цэвэр усны орлогыг хэрэглэгч тус бүрээр нэхэмжлэл үүсгэж, төлбөрийг

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

баримтжуулаагүй, тооцооны дансаар дамжуулалгүйгээр 2,202.8 мянган төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна.

Өгсөн зөвлөмж: Усны төлбөрийн орлогыг тооцооны дансаар дамжуулан бүртгэж байх, үндсэн хөрөнгийн элэгдлийг тооцож, 2024 оны санхүүгийн тайланд залруулах.

Аудитаар нийт **13,428.0** мянган төгрөгийн зөрчил² илэрч зөрчлийг арилгах 5 албан шаардлага, 1 зөвлөмж өгөгдөв.

5.1 Албан шаардлага:

5.1.1. ЗДТГ нь төсвийг үр ашиг, арвилан хэмнэлттэй зарцуулах зарчмыг алдагдуулан "Аймгийн арслан" цол хүртсэн Баттөрийн Ганбаярын цолны мялаалгад баг хорооны үйл ажиллагааны зардлаас нийт **3,914.1** мянган төгрөгийг зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу, үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулж байх албан шаардлага хүргүүлэв.

5.1.2. Засаг даргын нөөц хөрөнгийн батлагдсан төсвөөс гадаад томилолтын зардалд арга хэмжээ хооронд зориулалт бусаар **1,905.0** мянган төгрөгийг зарцуулж, санхүүгийн тайланд үнэн зөв илэрхийлээгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.2.1.1 дэх "Гадаад, дотоод албан томилолтын зардал" гэсэн заалтууд болон Сангийн сайдын 2015 оны 7 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан "Зардлын зориулалт болон арга хэмжээний ангилал"-ыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, шаардлагатай бол төсөвт зохицуулалт хийлгэх албан шаардлага хүргүүлэх.

5.1.3. Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүйгээс дараах **7,079.5** мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргасан байна. Үүнд:

- ЗДТГ нь батлагдсан төсвийг зардлын бүлэг хооронд гүйлгэн, зориулалт бусаар нийт **2,190.3** мянган төгрөгийг /цалингийн зардлаас ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд 654.4, засаг даргын нөөц хөрөнгөөс цэвэр, бохир усны зардалд 487.1 мянган төгрөгийг, урсгал засварын зардалд 140.0 мянган төгрөгийг, бараа ажил үйлчилгээний бусад зардлаас бага

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

үнэтэй түргэн элэгдэх эд зүйлс худалдан авахад 908.8 мянган төгрөг гэх мэт/ зарцуулж, гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

- ЗДТГ нь төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянан баталгаажуулаагүйн улмаас цалингийн зардлаас нийгмийн даатгалын шимтгэлийг илүү шилжүүлж **4,199.2** мянган төгрөгийн авлага үүсгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “Төсвийг зохистой удирдаж, авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ: дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.
- ЗДТГ нь албан томилолтоор ажилласан албан хаагчид унааны баримтгүйгээр буюу анхан шатны баримтын бүрдэлгүйгээр албан томилолтын зардлаас **690.0** мянган төгрөгийг олгож, бүртгэл тайланд тусгасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.7 дахь “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх “...хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй ... нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно” гэсэн заалтын дагуу ЗДТГ-ын дарга А.Одхүү, нягтлан бодогч Ч.Мөнхзаяа нарт сахилгын шийтгэл ногдуулах, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

5.1.4. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр буюу ОНЕО-ын дансанд бүртгэлтэй 2010-2011 онд 5 иргэнд олгосон итгэлийн зээлийн төлөгдөөгүй үлдэгдэл, ЗДТГ-ын дансанд бүртгэлтэй “Гавшгай ус” ААТҮГ-аас авах усны авлага зэргийг барагдуулахаар хууль, хяналтын байгууллагад шилжүүлэх зэргээр үр нөлөө бүхий арга хэмжээ аваагүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

5.1.5. ЗДТГ нь 12 айлын орон сууцыг түрээслүүлсний орлогын 20 хувь болох **529.4** мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлээгүй нь аймгийн ИТХ-ын 2014 оны 25 дугаар “Орон нутгийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлэх журам, түрээсийн төлбөрийн хэмжээг батлах тухай” тогтоолын 2.14 дэх “... түрээсийн төлбөрийн

нийт дүнгийн 20 хувийг орон нутгийн хөрөнгө худалдан борлуулсны орлогын дансанд байршуулна.” гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Түрээсийн орлогыг тухай бүр тогтоосон хувь хэмжээгээр тооцон, төсөвт төвлөрүүлж байх албан шаардлага хүргүүлэв.

5.2 Зөвлөмж

Татварын тайлантай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант оны эцэст ЗДТГ болон ИТХ нь татварын хөнгөлөлтийн тооцооллыг хийгээгүй нь ХХОАТ-ын авлага үүсэх эрсдэлийг үүсгэсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Татварын хөнгөлөлтийн тооцооллыг бодитоор тооцож, 2024 оны татварын тайланд залруулж, санхүүгийн тайланд үнэн зөв тусгах.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5³ дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2024 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

³ Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

6. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
ИТХ	1	40.0	1	40.0			1	40.0				
ЗДТГ	4	21,450.6	4	21,450.6			2	18,201.7	2	3,248.9	2	3,248.9
Дүн	5	21,490.6	5	21,490.6			3	18,241.7	2	3,248.9	2	3,248.9

/мянган төгрөгөөр/

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Т	О	Тоо	Дүн
ТТЗ	1				1							
ИТХ	1											
ЗДТГ	4	13,428.0			3	13,428.0			1	2		
Дүн	6	13,428.0			4	13,428.0			1	2		

/мянган төгрөгөөр/

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Байгууллагын нэр	/мянган төгрөгөөр/							
	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Үүнээс		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Нийт 57 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.	1				1			
Дүн	1				1			
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн	1				1			